

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэвсэгт хүчний 113 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2022/71/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай 2022 он	Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Ахлах аудитор: С.Шийлэгмаа Утас: 70323833 Цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 113 ДУГААР
АНГИЙН ЗАХИРАГЧ Б.ГАЛБАТ
ТАНАА

2022.01.19 № 32
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэвсэгт хүчний 113 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зэвсэгт хүчний 113 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 24 нэр төрлийн 10,091.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, буцалтгүй хандив тусламжаар баригдсан 28,405.0 мянган төгрөгийн барилга байгууламжийг тайланд тусгаагүй зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Бодитой оршин байх, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна..

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

015030063

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	88.2	125.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	251.9	668.0
	Нийт хөрөнгийн дүн	340.2	811.3
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	340.2	811.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	340.2	811.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	724.1	1090.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	711.1	619.2
	Үйл ажиллагааны үр дүн	13.0	471.2
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	13.0	471.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327.2	340.2
	Тайлант оны үр дүн	13.0	471.1
	Эцсийн үлдэгдэл	340.2	811.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	682.7	596.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	682.7	596.2
	Үйл ажиллагааны ЦМГ		
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	682.7	596.1
	Урсгал зардал	682.7	596.1
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	682.7	596.1
	Улсын төсвөөс санхүүжих	682.7	596.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зэвсэгт хүчний 113 дугаар анги нь Анги, ротын цэргийн сургалтын бодлогыг тодорхойлж, цэргийн сургалт бэлтгэлийн стандарт, хөтөлбөр, арга зүй, хяналт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа шинжилгээний ажил, хамтарсан сургалт,

дадлагыг нэмэгдүүлэх замаар анги, харьяа ротуудын бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэхэд оршино.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Тус байгууллага нь бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 24 нэр төрлийн 10.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, буцалтгүй хандив тусламжаар баригдсан 28.5 сая төгрөгийн барилга байгууламжийг тайланд тусгаагүй зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Бодитой оршин байх, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнээс бусад эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэхэд 2 горим сорилд алдаа зөрчил илэрч, 3 горим сорилд алдаа зөрчил илрээгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зэвсэгт хүчний 113 дугаар анги нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Зэвсэгт хүчний 113 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 38.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн.

Албан шаардлага

Ар талын байр 12х11 м2 хэмжээтэй 1 давхар барилгыг 2019 онд 28.4 сая төгрөгийн хандиваар барьсан барилгыг одоог хүртэл үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлд тусгаагүй байна.

Сургалтын тоног төхөөрөмж, Хүнсний сав баглаа боодол, Орон сууц гэх эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 24 нэр төрлийн 10.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүд бүртгэлтэй байна.

Зөвлөмж

Бараа материалын тайланг батлагдсан маягтаар сар бүр гаргаагүй хагас бүтэн жилээр гаргасан байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	3	38.5					2	38.5	1	
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	3	38.5					2	38.5	1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ										
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	3	38.5					2	38.5	1	

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР